



ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

20 ~~18~~ оны ~~09~~ сарын ~~14~~ өдөр

№ ~~27/18~~

Улаанбаатар хот

「Компанийн засаглалын зарчим батлах тухай」

Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн “Засаглалын зарчим”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн засаглалын зарчмыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /С.Цэрэндаш/-д үүрэг болгосугай.
3. Компанийн засаглалын зарчмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба /Б.Аюуш/-нд даалгасугай.

ДАРГА



Б.ДААЖАМБА

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2018 оны 09 дүгээр сарын 14 ний өдрийн  
29/18 дугаар тогтоолын Хавсралт



“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК

---

**“ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК-ИЙН  
ЗАСАГЛАЛЫН ЗАРЧИМ**

---

Улаанбаатар хот

2018 он

## АГУУЛГА

1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ
2. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ
  - 2.1. ТУЗ-ийн эрх, үүрэг
  - 2.2. ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн
  - 2.3. Манлайлал, хараат бус байдал
3. КОМПАНИЙН СОЁЛ, ЁС ЗҮЙ
4. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА
  - 4.1. Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг
5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
6. НИЙЦЭЛ
7. ДОТООД АУДИТ
8. ИЛ ТОД БАЙДАЛ
9. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ
10. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

## I. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн засаглалын тогтолцоо нь дараах үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд:

1. **Харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг эрхэмлэх** – Компанийн үйл ажиллагааны дүрэм журмыг боловсруулах, сангийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг ямагт тэргүүн ээлжинд харгалзан үздэг зарчмыг чанд баримтлан ажиллах замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн мэргэжлийн компани болон төлөвших нь компанийн засаглалын үндсэн зорилго байна.

2. **Мэргэжлийн ёс зүйтэй, сонирхлын зөрчлөөс ангид байх** – Хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх үндсэн хүчин зүйл болох компанийн соёл, ёс зүйн дүрмийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, баримт бичигт нийцүүлэн боловсруулж, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд бүгд чанд баримтлан ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох, урамшуулах тогтолцоо бүрдүүлнэ. Удирдлагын шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс ангид байх асуудлыг онцгой анхааран дээрх дүрэмд тусгасан байна.

3. **Бие даасан, хараат бус байх** – Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шийдвэр гаргахдаа тухайн төсөл нь улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оруулах хувь нэмэр, нийгэм эдийн засгийн болон байгаль орчинд үзүүлэх нөлөө, үр өгөөжтэй байдлыг харгалзан үзэж, улс төрийн нам, санхүү, эдийн засгийн аливаа бүлэглэл, мөн түүнчлэн хувьцаа эзэмшигчийн нөлөөнөөс хараат бусаар мэргэжлийн шийдвэр гаргах зарчмыг чанд баримтлана.

4. **Мэргэжлийн ур чадвартай, шударга байх** – Компанийн удирдлага, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг, дадлага туршлага, хариуцлагатай ажиллах чадвар нь хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх чухал хүчин зүйл болохыг харгалзан эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудад тавих шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоож, сонгон шалгаруулалтыг ил тод зохион байгуулах, цалин урамшууллыг зохистой тогтоох, ажлын байрандаа мэдлэг дадлага, ур чадвараа дээшлүүлэх боломж бүрдүүлнэ.

5. **Хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан ажиллах** – Компанийн болон удирдаж буй сангийн үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомж, дүрэм журмын болон олон улсын хөрөнгө оруулалтын зах зээлд нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, зөвлөмжийн мэдээллийн сан бүрдүүлэх, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, бүх шатны ажилтан санд чөлөөтэй нэвтрэн мэдээлэл авдаг байх, хууль дүрэм журам, стандартыг чанд мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо бүрдүүлэн ажиллана.

6. **Эрсдэлийн удирдлага, хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх** – Олон улсад нийтлэг дагаж мөрдөж буй стандарт, зарчимд нийцүүлэн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлнэ.

7. **Оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн зах зээлд үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх** – Оролцогч талуудын хууль болон гэрээгээр тогтоосон эрх ашгийг хүндэтгэн үзэж шийдвэр гаргадаг тогтолцоо бүрдүүлэх хөрөнгө оруулалтын мэргэжлийн байгууллага, зохицуулах байгууллагатай үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэнэ.

## II. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

Мэргэжлийн ур чадвар ёс зүйтэй, хараат бус, хариуцлагатай ТУЗ-тэй байх нь компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бөгөөд ТУЗ нь компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах, засаглалын оновчтой тогтолцоо бүрдүүлэхдээ гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн нэр хүндтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн удирдлагын Монгол компани болгон төлөвшүүлэх стратегийг зорилго болгоно.

ТУЗ нь дээр дурьдсан зорилгыг хэрэгжүүлэх чадавхитай гүйцэтгэх удирдлагыг сонгох, компанийн зохион байгуулалтын болон засаглалын бүтцийг оновчтой тогтоох, дотоод хяналтын, нийцлийн болон эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоо бүрдүүлэх ажиллагааг чиглүүлэх, хэрэгжилтийг хянах замаар хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулдаг, тэдний итгэлийг хүлээсэн компани болгон төлөвшүүлэх үндсэн үүрэгтэй.

### **2.1. ТУЗ-ийн эрх, үүрэг:**

Удирдаж буй сангийн хөрөнгийн үнэ цэнийг урт хугацаанд нэмэгдүүлэх, санхүүгийн хувьд тогтвортой, үр ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх;

Компанид байгууллагын соёл, үнэт зүйлийг төлөвшүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлэх ажиллагааг хянах, эрсдэлийн удирдлагын стандартыг нэвтрүүлэх асуудлаар хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын өмнө хариуцлага хүлээх;

ТУЗ-ийн гишүүд нь үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэлд тулгуурлан, компани болон нийт хувьцаа эзэмшигчид, удирдаж буй сангийн хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн, улс төрийн нам, санхүү эдийн засгийн аливаа бүлэглэл, компанийн гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс ангид, хараат бус, мэргэжлийн шийдвэр гаргах үүрэгтэй.

ТУЗ-ийн бүрэн эрхийг Компанийн тухай хууль, энэхүү зарчмын агуулгад нийцүүлэн Компанийн дүрэмд тусгах бөгөөд энэхүү зарчмыг хэвшүүлэх талаар дараах онцлог чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Компанийн засаглал, байгаль орчны болон нийгмийн хариуцлагын бодлогын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, дүгнэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Бизнесийн ёс зүй, компанийн соёлын стандартыг тогтоох, нэвтрүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Компанийн удирдаж буй сангаас хөрөнгө оруулалт хийх харилцаанд үүсч болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хянах тогтолцоо бүрдүүлэх;
- Эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдсэн эсэхэд хяналт тавих, удирдаж буй сан нэмэгдэх, сангийн хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт гарсан тухай бүр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хянаж, сайжруулах арга хэмжээ авах;
- Компанийн цалин урамшуулал, хүний нөөцийн бодлого нь хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн чадварлаг баг бүрдүүлэх, засаглалыг сайжруулах, эрсдэлийг бууруулах зорилгод нийцэж байгаа эсэхийг хянах, сайжруулах чиглэл удирдамж өгөх;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл явц ил тод байх нөхцөлийг бүрдүүлэх;
- ТУЗ-ийн гишүүд нь “Дээрээ суудлаа олсон байх” /Tone at the top/ зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон хувийн үлгэр дууриал үзүүлэх чадвартай байх;
- Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон оролцогч талуудын хооронд идэвхтэй, байнгын харилцаа бүрдүүлэх, олон нийттэй харилцах харилцаанд дэмжлэг үзүүлэх, компанийн эрх бүхий албан тушаалтныг засаглалтай холбоотой мэдээллээр хангах ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх ур чадвартай, туршлагатай, нэр хүндтэй нарийн бичгийн даргыг сонгон ажилуулах;
- ТУЗ-ийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах, үр дүнг сайжруулах, тодорхой асуудалд онцгой анхаарал хандуулж, мэргэжлийн үүднээс хандах боломж

бүрдүүлэх зорилгоор ТУЗ байнгын болон түр хороодыг байгуулан ажиллуулж болох бөгөөд аудитын, эрсдэлийн, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороог заавал байгуулж, чиг үүрэг, дүгнэлт шийдвэр гаргах эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим зэргийг журамласан байна.

- Засаглалын энэхүү зарчмыг хэрэгжүүлэх чадавхтай гүйцэтгэх удирдлагыг сонгох, урамшуулах, хяналт тавих, гүйцэтгэх удирдлагын залгамж чанарыг хангах бодлогыг хэрэгжүүлэх;
- Засаглалтай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчид, сангийн хөрөнгө оруулагчид болон оролцогч талууд, зохицуулах байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллах, тогтмол санал солилцох боломж бүрдүүлэх;
- ТУЗ-ийн үйл ажиллагааг энэхүү зарчимд нийцүүлэн зохион байгуулах асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан байх.

## **2.2. ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн**

ТУЗ нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай мэдлэг, чадвартай, хөрөнгө оруулалтын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, аливаа хууль бус үйлдэлд нэр холбогдоогүй, ял шийтгэлгүй, ёс зүйтэй гишүүдээс бүрдсэн байх бөгөөд гишүүдийг үр дүнтэй, хамтран ажиллах чадвартай баг болгон хариуцлагатай ажиллуулах нь ТУЗ-ийн даргын үүрэг байна.

ТУЗ-ийн гишүүдийн олонхи нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүд нь Компанийн тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шалгуурыг хангасан байна:

- хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр ажилласан туршлагатай, санхүү, банк, аудит, бизнесийн эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд олон улсын хөрөнгө оруулалтын менежментийн салбарт ажилласан бол давуу талтай байна;
- өөрөө эсхүл холбогдох этгээд нь улс төрийн аль нэг намын удирдах дээд байгууллагад сонгогдоогүй, удирдах албан тушаал хашдаггүй;
- Монгол Улсын Хөгжлийн банкны болон компанийн ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш, мөн банкны болон түүний охин, хараат компанийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа бизнесийн төсөл, хөтөлбөрийн захиалагч, гүйцэтгэгч болох хуулийн этгээдийн болон уг этгээдийн хамаардаг компанийн нэгдлийн оролцогчдын эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш;
- төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн албан хаагч биш;
- компанитай бизнесийн аливаа холбоогүй.

*Тайлбар: 1/ Холбогдох этгээд гэдгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлно.*

*2/ Бизнесийн холбоо гэдгийг компани тухайн этгээд болон түүний холбогдох этгээдтэй өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 0.01%-иас илүү үнийн дүн бүхий бэлтгэн нийлүүлэх, ажил үйлчилгээ үзүүлэх, худалдан авах зэрэг аливаа гэрээ хэлцэл хийснийг ойлгоно.*

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд тавигдах тусгай шаардлага, тэднийг томилох харилцааг Компанийн дүрэм, холбогдох журамд тусгаж, ТУЗ-ийн гишүүн бүр энэхүү шаардлагыг хангаж байгаа эсэхэд жил бүр хяналт тавина.

## **2.3. Манлайлал, хараат бус байдал**

ТУЗ-ийн гишүүд “Дээрээ суудлаа олсон байх” /Tone at the top/ зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон компанийн ажилтнуудад хувийн үлгэр дууриал үзүүлэхүйц мэдлэг, ур чадвартай, ёс зүйтэй байх нь ТУЗ-ийн манлайллыг хэрэгжүүлэх гол нөхцөл болно. Үүний хүрээнд дараах асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай:

- **ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх:** ТУЗ өөрийн болон гишүүдийн үйл ажиллагаанд жил бүр үнэлэлт өгөх бөгөөд энэхүү үнэлэлт, дүгнэлтийг хэлэлцэх хуралд бүх гишүүд оролцоно.
- **ТУЗ-ийн гишүүний хавсран гүйцэтгэх ажил, сонирхлын зөрчил:** ТУЗ-ийн гишүүний хавсран эрхэлж буй ажил, үйлчилгээ нь тухайн гишүүний компанийн өмнө хүлээж буй үүрэг хариуцлагад нөлөөлөхгүй байх шаардлагатай. ТУЗ-ийн гишүүн компанийн нууцад хамаарах мэдээлэл болон дотоод мэдээллийг задруулах, бусдад дамжуулахыг хориглоно. Тодорхой асуудлаар шийдвэр гаргах үед ТУЗ-ийн аль нэг гишүүн эсвэл гишүүдэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ талаар зөвлөлд урьдчилан мэдэгдэж, санал хураалтад оролцохгүй.
- **ТУЗ-ийн гишүүдийн сургалт:** Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх, компанийн үйл ажиллагааны болон засаглалын зарчмын талаарх мэдээллээр хангах зорилгоор албан ёсны танилцуулах уулзалтыг зохион байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд компанийн ажилтан, хөндлөнгийн зөвлөхийг оролцуулсан уулзалт зохион байгуулах, сургалт семинарт оролцуулах замаар тэднийг сургах, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

ТУЗ нь тодорхой асуудлаар иж бүрэн тооцоо судалгаа, бодитой мэдээлэлд үндэслэн хараат бус мэргэжлийн шийдвэр гаргах, засаглалын зарчмыг чанд мөрдөн ажиллах чадвартай байх ёстой. Үүний тулд дараах зарчмыг удирдлага болгон үйл ажиллагаа явуулна:

- Шийдвэр гаргахад шаардлагатай танилцуулга мэдээллийг цаг тухайд нь хүлээн авдаг, ийнхүү хүлээн авсан тухайгаа хариу мэдэгддэг, мэдээлэл тодруулга шаардлагатай бол энэ тухай ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэж, нэмэлт мэдээлэл авдаг журмыг хэвшүүлсэн байх;
- Шийдвэр гаргахдаа холбогдох дүрэм журмаар тогтоосон сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг чанд баримтлах;
- ТУЗ-ийн хурлаар асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, дотоод хяналтын албаар дамжуулан хяналт тавихаас бусад хэлбэрээр компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх.

### III. КОМПАНИЙН СОЁЛ, ЁС ЗҮЙ

Компанийн эрхэм зорилго нь бизнесийн ёс зүйн шилдэг жишигт нийцсэн байх зарчимд тулгуурлан компанийн соёл, ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлэх, хэрэгжилтийг хянах нь ТУЗ-ийн үүрэг байна. Энэхүү дүрэм нь компанийн стратеги, эрсдэлийн удирдлагын болон цалин урамшуулын тогтолцоотой нягт уялдсан байх бөгөөд дараах асуудлыг хамарсан байна:

- **Авилгын эсрэг бодлого:** Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан авилгад өртөхөөс сэргийлэх дүрэм журам тогтоон мөрдүүлэх;
- **“Шүгэл үлээх” боломж:** Компанийн ажилтнууд, сангийн хөрөнгө оруулагчид болон бусад үйлчилгээ үзүүлэгч компаниудын зүгээс компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь компанийн соёл, ёс зүйн дүрэм болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн болон зөрчихөд хүргэхүйц үйлдэл, зан авир гаргаж байгаа талаар Гүйцэтгэх захиралд болон ТУЗ-д мэдээлэх зохистой механизм бүрдүүлэх;
- **Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйлдэл:** Удирдаж буй сангаас хөрөнгө оруулсан компанийн үнэт цаасны арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцохыг хориглох, ийм арилжаа хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих;
- **Дүрэм, журмыг дагаж мөрдөх:** Компанийн болон удирдаж буй сангийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг чанд

- мөрдөж хэвших нь эрх бүхий албан тушаалтан болон бүх ажилтны заавал мөрдөх үүрэг болох;
- **Эрсдэлийг бууруулах:** Эрх бүхий албан тушаалтан болон ажилтан үйлдэл бүрээ нягт хянаж, аливаа эрсдэлд хүргэх үйлдэл, эс үйлдэл хийхээс зайлсхийх үүрэгтэй гэдгийг сайтар ухамсарласан байх;
- **Сахилга, дэг журам:** Хөдөлмөрийн дотоод журамд заасан дотоод дэг журмыг нягт баримталж хэвшүүлэх, зөрчсөн тохиолдолд заавал хариуцлага хүлээдэг байх;
- **Хууль бус, ёс бус үйлдлийг таслан зогсоох тогтолцоо:** Залилан, худал мэдээлэл гаргах, бусдын нэр хүндэд хохирол учруулах, мөнгө угаахын эсрэг болон шударга өрсөлдөөний зарчмыг зөрчих, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглах, танил тал харах, харилцагч хөрөнгө оруулагчидтай болон бусад ажилтнуудтай ёс бус харилцах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, маргаан дэгдээх зэрэг компанийн нэр хүндэд хохирол учруулах зан авир гаргах зэргээр хууль бус, ёс бус үйлдэл гаргахгүй байх, гаргасан тохиолдолд хариуцлага тооцдог тогтолцоо бүрдүүлэх, урьдчилан сэргийлдэг, нөхөрсөг бүтээлч уур амьсгал бүрдүүлэх.

#### IV. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн чиглэл удирдамж, ТУЗ-өөс баталсан эрсдэлийн, дотоод хяналтын болон цалин урамшууллын бодлогод нийцүүлэн компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

##### 4.1. Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг

Мэргэжлийн ур чадвартай, хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжтой гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, компанийн стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхдээ энэхүү зарчмыг удирдлага болгох үүрэг хүлээнэ. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү зарчмыг хэвшүүлэх талаар дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Компанийн, хувьцаа эзэмшигчийн болон удирдаж буй сангийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэх зарчмыг ямагт баримтлан шийдвэр гаргадаг байх;
- Сонирхлын зөрчил үүсгэх аливаа үйлдлээс ангид байх бөгөөд сонирхлын зөрчил үүсэхээр нөхцөлд энэ талаар ТУЗ-д мэдэгдэж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- Компанийн зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, эрх бүхий албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг батлахдаа энэхүү зарчмыг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх удирдлагын хүлээсэн үүргийг албадын удирдлага эрх бүхий албан тушаалтанд хуваарилан оногдуулах асуудлыг тусгасан байх;
- Эрх бүхий албан тушаалтан болон ажилтныг сонгон шалгаруулах, тасралтгүй сургах дадлагажуулах, ажлын байранд мэргэшлийг нь дээшлүүлэх, шагнах урамшуулах, нийгмийн асуудалд нь тусламж дэмжлэг үзүүлэх журамтай байх бөгөөд түүнийг чанд баримтлан ажиллах замаар засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрддөг мэргэжлийн өндөр ур чадвартай, сахилгатай, хариуцлагатай, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн баг болон ажиллах чадавхитай хамт олныг бүрдүүлэх;
- Ажилтан бүрийн хариуцсан ажлын гүйцэтгэлийг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах хөшүүрэг болохуйц цалин, урамшууллын бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Компанид дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар ТУЗ-ийн өмнө хариуцлага хүлээж, дотоод аудитын нэгжийн шалгалтын мөрөөр ТУЗ-өөс гаргасан зөвлөмжийн дагуу сайжруулан боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг байх;



- Компанийн засаглал болон хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг удирдлага болгон үйл ажиллагааны, үүний дотор удирдаж буй сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх ажиллагааг зохицуулах дүрэм журам, заавар боловсруулан шаардлагатай үед ТУЗ-өөр батлуулан хэрэгжилтийг хангах;
- Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, явц үр дүнг нь хянах ур чадвартай, хараат бус хороог бүрдүүлэн, удирдаж буй сан тус бүрийн хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх;
- Компанийн үйл ажиллагаанд болон гадаад дотоод орчинд гарч буй өөрчлөлтийг цаг тухайд нь мэдэрч, хариу арга хэмжээ авах санал боловсруулан ТУЗ-д мэдээлдэг байх.

## **V. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

Компанийн үйл ажиллагаанд болон удирдаж буй сангийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдүүлэх нь компанийн засаглалын болон хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийн нэг болно.

### **5.1. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо**

Компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, өөрөөр хэлбэл ажилтан болон алба бүрийн, удирдаж буй сан тус бүрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах асуудлыг ажлын байрны тодорхойлолт боловсруулах, ажилтанд үүрэг даалгавар өгөх, дүгнэхдээ ямагт анхаардаг байх нь “эрсдэлээс хамгаалах хамгаалалтын тэргүүн шугам”-ыг бий болгоно.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд “эрсдэлээс хамгаалах хоёрдох шугам” нь эрсдэлийн удирдлагын бие даасан нэгж байх бөгөөд тухайн нэгжийн эрх үүрэг, шийдвэр гаргах хүрээ, хариуцлага болон тайлагнах зарчмыг оновчтой тогтоох нь гүйцэтгэх удирдлагын үүрэг байна.

Эрсдэлийн удирдлагын нэгжийг байгуулахдаа дараах асуудалд анхаарал хандуулна:

- Эрсдэлийн удирдлагын нэгжийн ажилтан нь компанийн болон удирдаж буй сангийн дотоод мэдээллийн системд нэвтрэх эрхтэй байх бөгөөд хариуцаж буй сангийн талаар бүхий л мэдээллийг тухай бүр хүлээн авах эрхээр хангагдсан байна.
- Эрсдэлийг судлах, дүгнэх, бууруулах талаар үндсэн үйл ажиллагааны нэгжүүдээс хийж гүйцэтгэсэн ажлыг нэгтгэн дүгнэж, эцсийн үнэлгээ хийх, зөвлөмж өгөх үүрэг хүлээх, энэ үүргийг хэрэгжүүлэх чадавхитай баг бүрдүүлэх;
- Компанийн эрсдэл даах сонирхол, эрсдэлийн хязгаарын талаар санал боловсруулж, Гүйцэтгэх захиралд танилцуулан, ТУЗ-өөр батлуулах;
- Удирдаж буй сангийн хөрөнгө оруулах төслийн эрсдэлийн талаар үндсэн үйл ажиллагааны нэгжээс хийж гүйцэтгэсэн судалгааны тайланд дүгнэлт гаргах, санал боловсруулах.

## **VI. НИЙЦЭЛ**

Компанийн ТУЗ нь нийцлийн /комплаенс/ эрсдэлийг Эрсдэлийн удирдлагын нэгжээр дамжуулан удирдах, хянах үүрэгтэй. Нийцлийг тодорхойлох, үнэлэх, байнгын хяналт тавих, тайлагнах болон нийцлийг сайжруулах талаар зөвлөмж боловсруулах асуудал хамаарна. Нийцлийн удирдлага, хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлсэн байх нь

компанийн соёлын чухал асуудал бөгөөд компанийн үнэ цэнийг өсгөх үндсэн хүчин зүйлийн нэг байна.

- Компанийн нэгж болон удирдаж буй сан тус бүрээр нийцлийг тодорхойлох, хянах асуудлыг хамарсан нийцлийн хяналтын тогтолцоо бүрдүүлж, ТУЗ-өөр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах нь гүйцэтгэх удирдлагын үүрэг байна.
- Компани, удирдаж буй сангийн үйл ажиллагаанд болон ажлын байр, ажилбар бүрийн хувьд дагаж мөрдөх хууль, дүрэм журам, стандартын жагсаалт гаргах, хэрэгжүүлэх талаар ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, удирдамж, зөвлөмж боловсруулах, нийцэлтэй холбоотой тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгөх зэрэг нь нийцлийн хяналт хариуцсан дотоод аудитын албаны чиг үүрэгт хамаарна.

## **VII. ДОТООД АУДИТ**

Дотоод аудитын нэгж нь компанийн хяналтын болон эрсдэлийн удирдлага, засаглалын тогтолцооны талаар хараат бус дүгнэлт гаргаж, сайжруулах асуудлаар зөвлөмж боловсруулан ТУЗ-д танилцуулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулахад нь гүйцэтгэх удирдлагад зөвлөх үүрэгтэй байх бөгөөд компанийн “эрсдэлээс хамгаалах хамгаалалтын гуравдахь шугам”-ын үүрэг гүйцэтгэнэ.

- Дотоод аудитын нэгж нь компанийн мэдээллийн системд нэвтрэх эрхтэй байхын зэрэгцээ уг албаны шаардсан бүхий л мэдээ, мэдээлэл тайланг танилцуулах нь бүх алба болон ажилтны үүрэг байна;
- Дотоод аудитын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болон зөвлөмжүүд тухайлбал, COSO-гийн зарчим болон Дотоод аудитын олон улсын институтын стандартыг мөрдөнө;
- Дотоод аудитын албаны ажилтнууд нь компанийн үндсэн үйл ажиллагааны дүрэм журам, зөвлөмж, стандарт зэргийг мэддэг, энэ чиглэлээр суралцах, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх боломжоор хангагдсан байна;
- Компанийн ТУЗ нь дотоод аудитын нэгжийн ажилтнуудыг томилох, цалин хөлсийг тогтоох, бусад шаардлагатай дэмжлэг үзүүлэх замаар гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

## **VIII. ИЛ ТОД БАЙДАЛ**

Компанийн болон удирдаж буй сангийн үйл ажиллагааны талаар зөвшөөрөгдсөн мэдээллийг эрх бүхий этгээдэд цаг тухай бүр тогтоосон хэлбэрээр хүргэдэг байх, эдгээр мэдээлэл нь бодитой, үнэн зөв, баталгаажсан байх нь хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх үндсэн нөхцөлийн нэг мөн.

- Гүйцэтгэх удирдлага компанийн зорилго, засаглалын бүтэц, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хувьцаа эзэмшигчдийн бүтэц зэрэг дүрэм журмаар тогтоосон мэдээллийг хувьцаа эзэмшигчид болон зохицуулах байгууллагад хүргэх, ил тод болгох үүрэгтэй;
- Удирдаж буй сангийн хөрөнгө оруулагчдад хүргэх, бусад оролцогч талуудад хүргэх зэргээр мэдээллийг ангилах бөгөөд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомж, хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээ, Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд, зохицуулах байгууллагад, хөрөнгө оруулагчдад хүргэхээр тогтоосон мэдээллийг цаг тухайд нь хүргэх тогтолцоо бүрдүүлсэн байх бөгөөд уг мэдээлэл бүрэн, үнэн зөв, цаг хугацаандаа байх асуудлыг хариуцах ажилтанг томилсон байна;
- Мэдээллийг нийтэд хүргэх харилцааг өөрийн цахим хуудсаар дамжуулан хэрэгжүүлнэ;

- Компани дотоод мэдээлэл эсхүл нууцын зэрэглэлтэй мэдээллийн талаарх хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавина.

## **IX. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах явцад сонирхлын зөрчил үүсэх явдал олонтоо тохиолддог бөгөөд энэхүү зөрчлийг зохицуулах журам нь ойлгомжтой, тодорхой байх нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний итгэлийг хүлээхэд онцгой ач холбогдолтой.

- Сонирхлын зөрчил үүссэн үед эрх бүхий албан тушаалтан энэ тухайгаа мэдэгдэх, тухайн асуудлыг шийдвэрлэхэд оролцохгүй байх, мэдэгдэлгүй сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргаснаас бусдад хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан байх ёстой.
- Төрийн өмчит компани болохын хувьд өмчлөгчийн эрх үүрэг, хянах зохицуулах эрх үүргийн хооронд үүсч болзошгүй сонирхлын зөрчлийг хэрхэн зохицуулах талаар ТУЗ тусгайлан анхаарч ажиллах үүрэгтэй.

## **X. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Компанийн зүгээс оролцогч талуудын хууль болон гэрээгээр тогтоосон эрхийг хүндэтгэн үзэх, компанийн ажилтнууд, хөрөнгө оруулагчид, хамтран ажиллагч байгууллагуудын ашиг сонирхол болон байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлыг байнга анхаарлын төвд байлгах, гаргаж буй шийдвэр нь оролцогч талууд болон тэдэнтэй хамтрах ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг харгалзан үздэг байх нь оролцогч талуудын итгэлийг хүлээх чухал нөхцөл мөн.

- Компани оролцогч талуудтай хамтран ажиллахдаа холбогдох хууль, дүрэм, гэрээ хэлцлийг мөрдөж ажиллах ба оролцогч талуудын хууль, журамд заасан эрх ашгийг зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй. Мөн түүнчлэн оролцогч талуудыг компанитай холбоотой бөгөөд зөвшөөрөгдсөн асуудлаар мэдээлэл авах боломжоор хангаж, үнэн зөв мэдээлэл өгнө.
- Компани ажилтантай байгуулах Хөдөлмөрийн болон Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд компанийн болон, ажилтны хүлээх үүрэг хариуцлагыг тусгаж, хэрэгжилтийг хянах тогтолцоо бүрдүүлэн ажиллах ба компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хууль бус, ёс зүйгүй үйлдлийн талаар ажилтнууд ТУЗ-д чөлөөтэй мэдээлж шийдвэрлүүлэх эрхтэй байх бөгөөд компанийн гүйцэтгэх удирдлага тэдний эрхийг аливаа дүрэм журмаар хязгаарлахгүй.
- Компанийн нийгмийн хариуцлага, хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг холбогдох дүрэм журамд тусгахдаа хариуцлагатай хөрөнгө оруулалтын болон компанийн нийгмийн хариуцлагын тухай олон улсын стандартад нийцүүлсэн байна.
- Компани нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын менежерүүдтэй хамтын ажиллагааг эрчимжүүлэх бодлого баримтална.
- Бусад сангуудтай зөвшилцөн санхүүжигч компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нэгдмэл байр суурьтай оролцох замаар тэдгээрийн засаглал, удирдлага болон бусад шийдвэрт зохистой нөлөө үзүүлэхийг эрмэлзэнэ

- Бусад хөрөнгө оруулагчидтай зөвшилцөх, хамтран ажиллахдаа зах зээлийг урвуулан ашиглах, үгсэн хуйвалдахыг хориглосон хуулийн зохицуулалтыг зөрчихөөс сэргийлнэ;
- Хөрөнгө оруулалтын зах зээлд хамтын болон байгууллагын хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг дэмжих, зохицуулах зорилготой ТББ-ыг үүсгэх, ийм байгууллагад нэгдэхийг дэмжинэ.
- Компани нь хөрөнгийн зах зээлийг хянах зохицуулах байгууллагатай хариуцлагатай хөрөнгө оруулалт болон компанийн засаглалын зарчмыг хэвшүүлэх асуудлаар хамтран ажиллах, санал солилцохыг эрхэмлэнэ.
- Зохицуулах байгууллагаас санаачилсан хэлэлцүүлэг, семинар зэрэг арга хэмжээнд идэвхтэй оролцох, туршлага мэдээлэл солилцох;
- Хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нөлөөлнө гэж үзвэл шинээр боловсруулж байгаа болон нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хууль, дүрэм, журмын төслийг судлан саналаа тусгуулах, уг асуудлыг бусад хөрөнгө оруулагчидтай хамтран хэлэлцэх санаачлага гаргана.

----000----